



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/171

Булган сум

Гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн зарим сумын эмч, багийн эмч нарын ажлын хэрэгцээг хангахад шаардагдах 5 ширхэг зөөврийн компьютерыг 14,000,000 (арван дөрвөн сая) төгрөгөөр "Оч нет" ХХК-тай хууль, журмын хүрээнд гэрээ байгуулж, хяналт тавьж хүлээн авахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

2. Санхүүжилтийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын батлагдсан төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

3. Зөөврийн компьютерыг бүртгэж, тайлагнахыг хүлээж авсан сумын Эрүүл мэндийн төвүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ

